


Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн ажлын явцын танилцуулга

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 3 тогтоолоор нийслэл хотын хэмжээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх 26 байршил, 82 хэсэгчилсэн талбайг баталсан. Энэ нь 18,843 нэгж талбар буюу 1656 га газрыг эзэлж байна. Тус байршлуудад батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 148,323 айлын орон сууц, 60 сургууль, 92 цэцэрлэг, 14 эмнэлгийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг нийт 36 компани төсөл хэрэгжүүлэгчийн төсөлд шалгарсан цаг хугацаа төсөл хэрэгжих талбайн онцлог зэргээс хамааран төслийн ажлын явц харилцан адилгүй байна. 2025 оны байдлаар 17 байршил 40 хэсэгчилсэн талбайд 38 төсөл хэрэгжүүлэгч батлагдсан барилгажилтын төсөл хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 3544 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн хэрэгжилт 18%-тай, 24513 айлын орон сууц ашиглалтад оруулж хэрэгжилт 16.5%-тай явагдаж байна.



АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ БУУЛГАН ШИНЭЭР БАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

Нийслэлийн иргэдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гамшигт байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор 2011 оноос эхлэн, 1970 оноос өмнө баригдсан 672 барилгад биет үзлэг, хэмжилт, судалгаа боловсруулан паспортжуулж, холбогдох хуулийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2016-2025 онд гарсан 10 удаагийн шийдвэрээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн орон сууцны зориулалттай 388 барилгын ашиглалтыг хориглосон.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу 2015 оноос хойш Нийслэлийн Засаг даргын 22 удаагийн захирамжаар 208 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан.

2016-2025 онд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 43 байршилд 5427 айлын үйлчилгээтэй орон сууц ашиглалтад оруулсан.

Ашиглалтад орсон барилгууд
/2015-2025/

